



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2018 оны 3 дугаар улирал



БАНКНЫ САЛБАРЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО



 www.mba.mn

 facebook.com/MongolianBankersAssociation

 twitter.com/Mongolianbanker

 +976 11 323581

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


2018 оны 3-р улиралд эдийн засгийн өсөлт 6.4 хувьд хүрсэн бөгөөд 2018 он гарсаар эхний 3 улирал дараалан 6.0-с дээш хувийн хувийн өсөлттэй гарлаа. Мөн 2014 оноос хойш эдийн засгийн өсөлт хамгийн өндөр түвшиндээ хүрч буй тохиолдол болж байна. Ингэснээр 2018 оны Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн нэрлэсэн дүнгээр 23.5 их наяд төгрөгт хүрлээ. Уул уурхайн салбарын өсөлт 0.6 болж өмнөх улирлаас 1.0 пунктээр буурсан хэдий ч өмнөх жилийн мөн үед -0.7 хувийн бууралттай гарч байсантай харьцуулахад өссөн үзүүлэлт юм.

Уул уурхайн бус салбар 8.1 хувиар өссөний дотор боловсруулах үйлдвэр 10.1 хувиар, тээврийн салбар 9.3 хувиар, бүтээгдэхүүний цэвэр татвар 22.9 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд голлох хувь нэмрийг орууллаа. Гагцхүү барилгын салбар бууралттай буюу тодруулбал 6.1 хувиар агшсанаар сүүлийн 2 улирал дараалан буурсан үзүүлэлтийг зааж байна. Ипотекийн зээл олголт буурсан нь барилгын салбарын өсөлтөд шууд нөлөөлөх хүчин зүйл болсон нь дамжиггүй.


Улсын инфляци өмнөх улирлаас буурч 5.7 хувьд хүрснээр 1 жилийн өмнөх түвшиндээ хүрч байна. Хэрэглээний үнийн индекс сүүлийн 4 улирал 5.5-7.0 хувьд хэлбэлзэж байгаа бөгөөд шатахууны үнийн өсөлтийн нөлөөлөл ороогүй байгаа дүн юм. 10-р сарын тоон мэдээллээс харахад инфляцийн түвшин нэмэгдэж 6.3 хувьд хүрсэн байгаа бөгөөд шатахууны үнийн өсөлтийн нөлөө бүрэн илрэх хүртэл буюу он дуустал үргэлжлэн өсөх төлөвтэй байна.

2018 оны 7-р сараас хойш тогтворжоод байсан ам.долларын төгрөгтэй харьцах ханш 3-р улиралд 90 төгрөг буюу 3.6 хувиар чангарч 2500 төгрөгийн босго даваад байсан бол 11-р сарын эцсээр 2600 төгрөг давж огцом чангаараад байна. Гадаад худалдааны мэдээнээс үзэхэд импортын төлбөрт өмнөх 2 улирал дараалан 1.6 тэрбум доллар зарцуулсан нь үүнээс өмнөх 5 улирлын дундажтай харьцуулахад 50 хувиар өссөн үзүүлэлт байгаа бөгөөд өөрөөр хэлбэл 2018 оны сүүлийн 2 улиралд ам.долларын эрэлт нэмэгджээ. Үүнээс гадна дэлхийн зах зээл дээр ам.долларын ханш бусад валютуудын эсрэг 3-50 хувь чангарч байгаатай харьцуулахад төгрөгийн ханшийн одоогийн сулралт нь тийм ч муу үзүүлэлт биш хэмээн Монголбанкны зүгээс мэдэгдэж байгаа.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ %



ИНФЛЯЦИ & M2



АМ. ДОЛЛАРЫН ХАНШ

(2018 онд)



ГАДААД СЕКТОР

2018 оны эхний 3 улирлын импортын нийт хэмжээ 2017 оны жилийн нийлбэр дүнтэй тэнцүү байгаа нь төлбөрийн тэнцэл, тэр дундаа урсгал дансны алдагдлыг өсгөх гол хүчин зүйл боллоо. 2018 оны 3-р улирлын байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал 475 сая ам.доллар, урсгал дансны алдагдал 1.1 тэрбум ам.доллар байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад урсгал дансны алдагдал 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хэдийгээр импортын хэмжээ мэдэгдэхүйц өссөн хэдий ч гадаад худалдааны тэнцэл 109 сая ам.долларын ашигтай гарснаар 2018 оны гадаад худалдааны ашгийн хэмжээ 931 сая ам.долларт хүрч байна. Импортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд болох шатахууны импортын үнийн дүн 1-р улиралтай харьцуулахад 67 хувиар, суудлын автомашины импорт 61 хувиар өссөн нь өмнөх улиралтай харьцуулахад гадаад худалдааны ашиг буурахад нөлөөллөө.

Өмнөх улиралтай харьцуулахад экспортын хэмжээ 19 хувиар буурсан нь нүүрсний экспортын тоо хэмжээний бууралттай холбоотой байна. Тодруулбал 2018 оны 2 дугаар улиралд 11.5 сая тонн нүүрс экспортолж, түүхэн амжилт тогтоож байсан бол 2018 оны 3 дугаар улиралд ялимгүй буурч 9.1 сая тонныг экспортолсон байна. Нүүрсний үнийн хувьд 2018 оны түршид тогтвортой буюу 78 ам.доллар/тн байна.


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

(сая ам.доллар)




ГАДААД ХУДАЛДАА

(сая ам.доллар)



ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮНИЙ

(сая ам.доллар)



УЛСЫН ТӨСӨВ

2018 оны Монгол улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын дүн 6.5 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.4 хувиар өслөө. Ингэснээр орлогын төлөвлөгөө 19.1 хувиар давж биелсэн юм. Үүнээс НӨАТ-ын орлого 430 тэрбум төгрөгөөр, орлогын албан татвар 360 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь төсвийн орлого бүрдүүлэлтэд голлох нөлөөг үзүүллээ. Харин нийт зарлагыг 6.3 их наяд төгрөгт буюу өсөлтийг 8.7 хувьд хязгаарласнаар нэгдсэн төсвийн тэнцэл 242 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Нийт зарлага өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч нийт төсвийн 80 хувийг зарцуулж 1.6 их наяд төгрөгийг хэмнэсэн үзүүлэлттэй гарлаа. Төсвийн гол хэмнэлт нь хөрөнгийн зардал буюу тодруулбал шинээр барихаар төлөвлөсөн барилга байгууламжийн зардлаас 900 тэрбумыг хэмнэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Ингэснээр 2018 оны хувьд төсвийн нийт зарлагын 92 хувийг татварын орлогоор санхүүжүүлж чадсан байна. 2016 болон 2017 оны мөн үед дээрх үзүүлэлт харгалзан 58 хувь болон 76 хувь байснаас үзэхэд 2018 оны төсвийн зарцуулалтыг харьцангуй эрүүл, сахилга баттай байна хэмээн дүгнэж болохоор байна.


ТӨСВИЙН ОРЛОГО
(тэрбум төгрөг)



ТӨСВИЙН ЗАРДАЛ
(тэрбум төгрөг)



ТӨСВИЙН ТЭНЦЭЛ
(тэрбум төгрөг)




САНХҮҮГИЙН САЛБАР

2018 оны эхний улиралд бодлогын хүү болон зайлшгүй байх нөөцийн хувийг зэрэг бууруулсны нөлөө 2 дугаар улиралд гарч, нэг улирлын дотор зээлийн багц 13 хувиар өссөн бол 3 дугаар улиралд дээрх өсөлт саарч, зээлийн багцын өсөлт 1.9 хувьтай гарлаа. Ингэснээр банкны системийн зээлийн багц 16 их наяд төгрөгийн босгыг давсан бол харилцах хадгаламж мөн л 16.0 их наяд төгрөгт ойртсон үзүүлэлттэй байна. Гэвч 3 дугаар улиралд ам.долларын төгрөгтэй харьцах ханш 90 төгрөгөөр чангарсныг тооцвол банкны системийн зээл хадгаламжийн хэмжээ зөвхөн ханшийн тэгшитгэлийн нөлөөгөөр өссөн байгаа юм.


2018 оны 3-р улирлын байдлаар чанаргүй зээлийн багц 1,348 тэрбум төгрөгт хүрээд байсан бол ердөө нэг сарын дотор 600 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 1,950 тэрбум төгрөгт хүрсэн тохиолдол 10-р сард бүртгэгдлээ. Ингэснээр чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 12 хувь болж байна. Өнгөрсөн 2 дугаар улиралд банкуудын зээлийн эрсдэлийн сан огцом нэмэгдэж байсан бол 10-р сар гарснаар зээлийн чанар огцом муудсан үзүүлэлтүүд хоорондоо холбоотой байх нь дамжиггүй бөгөөд зээлийн ангилал буурсан бүртгэл нь хоцорч хийгдсэн байх магадлал өндөр. Зээлийг ангилахтай холбоотой зохицуулалтад өөрчлөлт ороогүй байхад зээлийн чанар огцом муудсанаас харахад зээлийн чанар нийтээрээ муудаж байгаа гэхээсээ илүү томоохон зээлүүдийн ангиллыг бууруулсантай холбоотой гарсан өөрчлөлт гэж үзэж байна.

Хөрөнгийн зах зээлийн гол үзүүлэлт болох ТОП 20 индекс 2018 оны 3 дугаар улиралд эргэн өсч 20,000 нэгжийн босгыг давлаа. Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 264.4 тэрбум төгрөг буюу 12.7 хувиар өсч, 2.3 их наяд төгрөгт хүрсэн амжилттай байна.


БАНКНЫ САЛБАР
(их наяд төгрөг)



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ %



ТОП 20 ИНДЕКС



Эх сурвалж

- Үндэсний Статистикийн Хороо
- Монголбанк
- Санхүүгийн зохицуулах хороо
- Монголын Хөрөнгийн Бирж